

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ 2023 ОНД
ХЯНАЛТАД ХЭРЭГЖИЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН 7 САРЫН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ТАНИЛЦУУЛГА**

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийгдэж буй хяналт-шинжилгээ үнэлгээний зорилго нь өнгөрсөн хугацаанд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, удаашралтай болон тасарч байгаа заалтыг судалж, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тогтоох замаар цаашид хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ашиглаж болохуйц шийдлийн хувилбаруудыг дэвшүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан мэдээлэл, түүнийг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт чанартай, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагуудыг болоод Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан **“БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”**-д заасан үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд явцын хяналт шинжилгээг тусгай удирдамж гарган аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 газар, хэлтэс, агентлагт зохион байгуулан зөвлөн тусалж ажиллалаа.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авхуулж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг тамгын газрын захиргааны зөвлөлийн хуралд танилцуулан удаашралтай хэрэгжиж буй тогтоол шийдвэрийг эрчимжүүлж ажиллахыг хурлын тэмдэглэлээр үүрэг болгох ажил хэвшил болоод байна.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Дундговь аймагт 2023 оны 07 сарын байдлаар хяналтад хэрэгжиж буй **43** шийдвэр: Засгийн Газрын тогтоол-20, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-19, ЗГ-ын албан даалгавар-4 нийт **43** заалтыг хяналтад авч хэрэгжүүлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны 07 дугаар сарын хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс авч нэгтгэн, Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор баталсан БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-д заасан үнэлгээ өгөх зааврын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 43 заалтын биелэлт 78.53 хувьтай байна. Хэрэгжилтийг үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 15 заалт нь нийт заалтын 35 хувийг
- Хэрэгжих шатандаа байгаа 15 заалт нь 35 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 4 заалт нь 9 хувийг
- Хэрэгжээгүй 0 заалт нь 0 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 9 заалт 21 хувийг эзэлж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд гол шалгуур үзүүлэлт болгон оруулж хэвшээд байна.

Графикаар харуулбал:



Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон биелэлтийг Dundgovi.gov.mn сайт болон төрийн байгууллагын цахим программ болох ep.e-Mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулж, мөн мэдээллийн самбарт байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн явцын хяналт шинжилгээгээр төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Нийт заалтын тоо	43	
Бүрэн хэрэгжсэн	100%	15
Хэрэгжих шатанд	70%	15
Хэрэгжилт хангалтгүй	30%	4
Хэрэгжээгүй	0%	0
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй /үнэлэх боломжгүй/	9
Хэрэгжилтийн дундаж хувь	78.53%	

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийг цаг хугацаанд нь багтаан тайлагнахад ахиц дэвшил гарч байгаа нь хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр шат шатандаа төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж, тайлан мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үүрэг чиглэл өгөх ажил хэвшил болсонтой холбоотой байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгай удирдамж, шалгуур үзүүлэлтийг урьдчилан гаргаж холбогдох газруудад хүргүүлэн, хяналт-шинжилгээний явцад болон дууссаны дараа ажил сайжруулах чиглэлээр тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох газруудад хүргүүлж хэрэгжилтийн явцад хяналт тавьж заавар, зөвлөмж нэгдсэн удирдлагаар хангаж ажилласны үр дүнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 78.53 хувьтай хэрэгжсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад шийдвэрийн 13 заалтыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ чиглэлээр холбогдох агентлагуудад чиглэл өгч ажиллах нь зүйтэй.

Шийдвэрүүд дундаас Засгийн газрын тогтоолын дундаж 73.08 хувийн хэрэгжилттэй буюу хамгийн бага хувийн үзүүлэлттэй байна.

Цаашид үр дүнг жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд тусгай шалгуур үзүүлэлт боловсруулан дүгнэх бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сарын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр хэлтэс, агентлагууд анхаарч ажиллах шаардлагатай.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа зохион байгуулсан ажлын үр дүнг бодитой, тоо баримттай тайлагнах

2. Бодлогын хэлтсүүд хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалтуудыг холбогдох агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэхдээ нэг удаагийн шинжтэй, жил бүр тогтмол гардаг, хэрэгжилт тогтмолжсон заалтуудыг нэг бүрчлэн шүүн үзэж хяналтаас хасуулах хэсэгт тэмдэглэгээ хийж ирүүлэх

ХЯНАСАН :

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДААРИЙМАА
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Л.МЯГМАРМЯДАГ